



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/42

Шивээговь сум

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах  
өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 04 дүгээр "Сумын 2024 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоол, сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан баярын үйл ажиллагааг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр сумын Төв талбайд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2.Баярын үйл ажиллагааг зохион байгуулах комиссыг 1 дүгээр, баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар, зарцуулагдах зардлын төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Холбогдох арга хэмжээг чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг комисст, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА



Сумын Засаг даргын  
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн  
... дугаар захирамжийн ...-р хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ  
ТЭМДЭГЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Ажлын хэсгийн дарга:

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Соёлын төвийн бүжгийн багш

3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

3 дугаар сургуулийн захирал

Цагдаагийн хэсгийн дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

“Шивээ-Овоо” ХК-ийн Хүний нөөцийн  
дарга

“Шивээ-Овоо” ХК-ийн Үйлдвэрчний  
эвлэлийн дарга

Нарийн бичгийн дарга:

Хөрөнгө оруулалт, Эдийн засаг  
төлөвлөлт, Худалдан авах ажиллагаа  
хариуцсан мэргэжилтэн

Сумын Засаг даргын 2024 оны 05-р сарын 31-ны өдрийн 1172 дугаар захирамжийн 2-р хавсралт



**“ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДӨР”-ИЙГ  
ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ “ХӨГЖӨӨНТ БАГА НАС”  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Шивээговь сумын Төв талбайд зохион байгуулна .
2. Төв тайлбайн өнгө үзэмж засаж сайруулах. /зурсан зургуудыг засаж сэргээх, шөнийн гэрэлтүүлэг гэх мэт/.
3. Төв тайзны арын фон /ОУ-ын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан үг ,үсэг, зураг бүхий АФИШ/
4. Ерөнхий хөтөлбөр гаргасан АФИШ.
5. Зураг авахуулах дурсамж үлдээх фон бүхий АФИШ.
6. Хөгжөөнт бага нас авьяаслаг хүүхдүүдийн 1 цаг 15 минутын тоглолт /СОЁЛЫН ТӨВ/
7. “МӨЛХӨӨ ЖААЛ” СӨБ 3-р цэцэрлэг
8. “ЭРДЭНЭСИЙН АРАЛ” НУУЦЫГ ОЛООРОЙ баг үүсгэж ажиллах, авхаалж самбаа, хурд шалгаруулах тэмцээн /нас 10-16/ хүүхдүүд оролцоно. ШОХК
9. “ДУГУЙН ТЭМЦЭЭН” дугуйтай хүүхэд бүрийг хамруулах /3-н насны ангилалтай/ байр шалгаруулж шагнах
10. “3/3” САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭН /насны ангилалтай -3/-9 байр шалгаруулж шагнах
11. “БУУХИА” ТЭМЦЭЭН /насны ангилалтай -3/-9 байр шалгаруулж шагнах.
12. “ГАР ЗУРАГ” /бүх насны хүүхдүүд /эхний 3 байр шагнаж урамшуулах
13. “ХӨЛ БӨМБӨГ” /медаль/
14. 18:00 цагаас чөлөөт нийтийн бүжиг /Соёлын төв/
15. 21:00 цагт кино гаргах



Сумын Засаг даргын  
 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн  
 1170 дугаар захирамжийн 3-р хавсралт

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ  
 ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Төрөл	Хүчин чадал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Тайз чимэглэх материал	багц	20	25'000	500'000
2	Чимэглэлийн уяа	метр	160	500	80'000
2	Салют	тайзны	2	60'000	120'000
3	Тоглолтонд оролцсон хүүхдийн бэлэг	ш	89	20'000	1'780'000
4	Хөөсөнцөр баннер хэвлүүлэх	6 м <sup>2</sup>	2	45'000	90'000
5	Хулдаасан баннер хэвлүүлэх	12 м <sup>2</sup>	8	20'000	160'000
6	Дугуйн уралдааны шагнал	ширхэг	9	30'000	270'000
<b>Нийт дүн</b>					<b>3'000'000</b>